

ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

20 ... оны ... дугаар
сарын ...-ний өдөр

№

Улаанбаатар хот

Хүний нөөцийн зөвлөх үйлчилгээний гэрээ-/цаашид “гэрээ” гэх/-г Нэг талаас: “.....” ХХК /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж гүйцэтгэх захирал....., нөгөө талаас: “.....” ХХК-ийн гүйцэтгэх захирал/цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар нь /цаашид хамтад нь “талууд” гэх/ Монгол Улсын Иргэний хууль, Хөдөлмөрийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1. “Гүйцэтгэгч” нь “Захиалагч”-ийн байрлах үйлдвэр буюу “.....” ХХК-ийн хүний нөөцийн менежментийн өнөөгийн төлөв байдалд шинжилгээ хийж, хүний нөөцийн бодлогыг тодорхойлон боловсруулах, зөвөлгөө өгөх, зөвлөмж бичих ажлыг мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн, “Захиалагч”-д актаар хүлээлгэн өгөх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авах, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. ГЭРЭЭТ АЖЛЫН ҮР ДҮН

- 2.1. Зөвлөх үйлчилгээний тайлан, дүгнэлтийн үр дүнд дараах зүйлсийг авч үзэж үнэлэлт өгөгдсөн байна:
- 2.1.2. Байгууллагын хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, хүний нөөцийн менежментийг оновчтой хэрэгжүүлэх арга зам, зөвөлгөө, зөвлөмж бичгийг хүлээн авна.
- 2.2. Гүйцэтгэгч нь тайлан, дүгнэлтийнхээ үнэн зөвийг хариуцана.

ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 3.1. Захиалагч нь Гүйцэтгэгчид тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсруулахад шаардлагатай дараах материалуудыг бүрдэл болгож өгнө. Үүнд:
- Шаардлагатай мэдээллээр хангах
 - Байгууллагын үйл ажиллагаатай танилцах болон судалгаа хийхэд шаардагдах албан томилолтын болон бусад зардлаар хангах
- 3.2. Гүйцэтгэгч тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргах ажлыг “Гүйцэтгэгч”-тэй харилцан тохиролцсон хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 3.3. Байгууллагын нууцыг чандлан хадгалахыг шаардах эрхтэй бөгөөд шууд болон шууд бус байдлаар компанийн нууцыг задруулсан нь тогтоогдвол шууд шүүх, арбтрын байгууллагад хандах эрхтэй.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 4.1. Тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргах ажлыг гэрээнд заасан нөхцлийн дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж үр дүнг гэрээнд заасан хугацаанд “Захиалагч”-д хүлээлгэж өгнө.
- 4.2. Зөвлөхийн тайлан, дүгнэлт, зөвлөмж нь үнэн зөв, хууль дүрмийн дагуу хийгдсэн байхыг хариуцна.
- 4.3. Гүйцэтгэж байгаа ажлын явц байдлын талаар “Захиалагч”-д тогтмол мэдээлж байна.

Үргэлжлэл бий ...